



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

「Нэмж гаргасан хувьцааг олон нийтэд танилцуулж,  
анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах  
хугацааг дахин сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178, 194, 226 болон 2021 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хатуу хөл хорио тогтоох” болон “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” арга хэмжээтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 689 дүгээр тогтоолоор бүртгэгдсэн “Сүү” ХК-ийн нэмж гаргаж буй 85,589,000 /наян таван сая таван зуун наян есөн мянга/ ширхэг хувьцааг олон нийтэд танилцуулж, захиалга авах хугацаа хойшлогдсон талаарх үнэт цаас гаргагч, андеррайтерийн компанийн хүсэлтийг үндэслэн нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд танилцуулж, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дахин ажлын 20 хоногоор сунгасугай.

2. Энэхүү тогтоолын 1-д заасан хугацаанд нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд танилцуулан, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж чадаагүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 689 дүгээр тогтоолоор бүртгэсэн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг “Сүү” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Ганбаатар/, “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК /Ц.Наран-Учрал/ нарт тус тус анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

